

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2017 оны 12 сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот


Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн 2017 оны үйл ажиллагаа нь ТЕГ-ын даргын 2017 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/13 дугаар тушаалаар батлагдсан “Татварын албаны 2017 оны үйл ажиллагааны зорилт”-д тодорхойлсон стратеги арга хэмжээ, Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд татварын асуудлаар тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдэн татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэн, нуугдмал орлогыг ил болгон татварын бааз суурийг өргөжүүлэх, татвар төлөх нийгмийн сэтгэлзүйг төлөвшүүлэх, боловсрол олгох, сургалт сурталчилгааны ажлыг дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан улс орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллалаа.

НЭГ. ЗАХИРГАА, САНХҮҮ, ХУУЛЬ ЭРХЗҮЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

1.1 Захиргаа, дотоод ажлын талаар

Бүтэц, зохион байгуулалт:

ТЕГ-ын даргын 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/03 дугаар “Татварын ерөнхий газрын харьяа эгжийн бүтэц чиг үүргийг батлах тухай” тушаалаар батлагдсан дүүргийн татварын хэлтсийн бүтэц чиг үүргийн дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.



Хүний нөөц:


Тус хэлтэс нь 2017 онд ТУАБ 8, ТУБ 77, үйлчилгээний ажилтан 8, хураагч 14, орон тооны бус байцаагч 13 нийт 120 албан хаагчидтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

№	Тасгийн нэр	Албан хаагчдын тоо	Хувь
1	Захиргааны тасаг	13	10.8%
2	Татварын орлогын тасаг	39	32.6%
3	Татварын хяналт шалгалтын тасаг	24	20%
4	Татвар төлөгчтэй харилцах тасаг	13	10.8%
5	Хувь хүний татварын тасаг	27	22.5%
6	Эрсдэл статистикийн тасаг	4	3.3%
	Нийт	120	100

Тайлант хугацааны хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн:

- Шилжин ирсэн-8
- Шилжин явсан-7
- Шинээр томилогдсон -15
- Хүүхэд асрах чөлөө, нөөцөөс орж ирсэн- 3
- Ажлаас чөлөөлөгдсөн-5
- Хүүхэд асрах болон чөлөөтэй байгаа-14

Нийт албан хаагчдын 99,8 хувь дээд боловсролтой, нягтлан бодогч, санхүү эдийн засагч, хуульч эрх зүйч мэргэжилтэй, төрийн захиргааны албан хаагчдын 90 хувь нь төрийн албаны зэрэг дэвтэй бөгөөд Татварын итгэмжит зөвлөх 2, Татварын зөвлөх 10, мэргэшсэн нягтлан бодогч 5 ажиллаж байна.



Нийт албан хаагчдын хувийн хэргийн баяжилт, бүрдүүлэлтийг тухай бүр хийж, хэлтсийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан, шилжилт хөдөлгөөн, мэдээллийн өөрчлөлт, шинэчлэлтийг Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системийн программ болон татварын албаны хүний нөөцийн программд бүрэн тусган шивэлт хийн ажиллалаа.

Дэг журам, сахилга бат, дотоод хяналт:

Албан хаагчдын сахилга хариуцлага, дэг журам, ажлын цаг ашиглалтанд хяналт тавих ажлын хүрээнд хэлтсийн Хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөн ажиллахын зэрэгцээ НЗД-ын 2017 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 02 дугаар “Сахилга хариуцлага дэг журмыг сайжруулах тухай” албан даалгавар, НТГ-ын даргын 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр “Сахилга хариуцлага дэг журмыг сайжруулах тухай” албан даалгаврыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 10 сарын 26-ны өдрийн “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврыг нийт албан хаагчдад танилцуулан гарын үсэг зуруулсан. Уг албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө Татварын албаны системийн хэмжээнд ТЕГ-ын даргын 2017 оны 11 сарын 07-ны өдрийн А/194 дүгээр тушаалаар батлагдан гарсан. Үүнтэй холбоотой тус татварын хэлтэс нь тасгийн дарга нартаа “Ёс зүйн мэдэгдэл” танилцуулан гарын үсэг зуруулан ажиллаж байна.

Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг хурууны хээгээр бүртгэх төхөөрөмжөөр бүртгэн хяналт тавихын зэрэгцээ тухайн өдрийн жижүүр байцаагч ажлын цагийн дундуур бүртгэлийг 2-оос доошгүй удаа хийдэг. Ажлын цагийн бүртгэлийг өдөр, сар, улирлаар нь нэгтгэн гаргаж долоо хоног бүрийн Мягмар гарагт зохион байгуулагддаг хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар танилцуулж, ажлын цаг ашиглалт хангалтгүй байгаа албан хаагчдад тохирох арга хэмжээг авч ажилласан.

Хэлтсийн Ёс зүйн салбар хороо ажлын цаг ашиглалтын зөрчилтэй албан хаагчдын зөрчлийг хэлэлцэж Ёс зүйн салбар хорооны дүгнэлтийг 2017 оны 04 сарын 24-ний өдрийн 1/915 тоот албан бичгээр ТЕГ-ийн ТЗУГ-т хүргүүлсэн. 2017 оны 11 сарын 27-ны өдрийн 03/3335 тоот албан бичгээр “сахилгын шийтгэл ногдуулах хөөн хэлэлцэх хагацаа нь шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан солигдон томилогдох хүртэлх хугацаанд дууссан тул сахилгын шийтгэл ногдуулах боломжгүй” гэсэн хариу ирсэн. Үүний дагуу гаргасан зөрчил, дутагдлыг дахин давтаж гаргахгүй байх талаар арга хэмжээ авч, цаг бүртгэлийг өдөр, сараар нарийвчлан гаргаж танилцуулан ажиллаж байна.

Ёс зүй, сахилга хариуцлагын талаар хэлтэс тасгийн хурал цуглаан бүрт нийт албан хаагч нарт анхааруулж мэдээлэл таниулга хийсэн. Мөн “Мэдээллийн цаг” дээр дээд газраас ирүүлсэн тушаал шийдвэр, цаг үеийн мэдээ мэдээлэл өгөх, ажлын цагийн бүртгэлийн танилцуулгыг тухай бүр танилцуулж ажилласан.

Тайлант хугацаанд иргэд татвар төлөгчдийн зүгээс хэлтсийн албан хаагчидтай холбоотой татварын албаны ажилтны ёс зүйн дүрэм, Татварын албаны үйлчилгээний стандартыг зөрчсөн тухай гомдол, санал гараагүй болно.

Шинээр ажилд орсон албан хаагчидтай Хөдөлмөрийн гэрээ байгуулахад Хэлтсийн Хөдөлмөрийн дотоод журам, Татварын албаны ажилтны ёс зүйн дүрэм, Татварын албаны үйлчилгээний стандарттай танилцсан тухай тэмдэглэл үйлдэж баталгаажуулсан.

2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр ТЕГ-ын Сургалтын төвөөс зохион байгуулсан "Харилцааны соёл, ёс зүй" сэдэвт сургалтанд хэлтсийн албан хаагчид бүрэн хамрагдсан.



2017 оны 4 сарын 25-ны өдөр Хувь хүний хөгжлийн үйл ажиллагаа, Нийгэмд хандсан төсөл хөтөлбөр зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “JCI Mongolia” олон улсын төрийн бус байгууллагатай хамтран “Ажлын байрны аз жаргал” сэдэвт сургалтыг зохион байгуулсан бөгөөд албан хаагчид маш идэвхитэй оролцсон.



Авилгын эсрэг үйл ажиллагаа:

Хэлтсийн 2017 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар баталгаажуулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус хэлтэст 2017 онд хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий нийт 84 татварын улсын байцаагч хуулийн хугацаанд ХАСХОМ-ыг 100% мэдүүлснийг хүлээн авч ХАСХОМ-1,2,3,4 тайлан мэдээг нэгтгэн ТЕГ-ын эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж ажилласан.

Авлигатай тэмцэх газраас гаргасан гарын авлага, тараах материалыг нийт албан хаагчдад тарааж, Төсөв санхүүгийн мэдээллийг тухай бүр гаргаж шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт электрон болон цаасан хэлбэрээр байршуулан олон нийтэд мэдээлж байна.

Мөн татварын алба хооронд шилжиж ирсэн, шинээр томилогдсон болон их хэмжээний өөрчлөлт орсон 3 ТУБ-ийн ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд гаргуулан авч хянаж бүртгэн ажиллалаа.

Хагас бүтэн жилээр хэлтсийн “Авлигын эсрэг үйл ажиллагаа”-ны төлөвлөгөөний биелэлт, тайланг ТЕГ-т хүргүүлэн ажилласан.

Авлигын талаарх мэдээлэл хүлээн авах санал хүсэлтийн хайрцгийг коридорт байрлуулан, иргэдээс албан хаагчдын авлигатай холбоотой мэдээллийг хүлээн авах эрх бийх албан тушаалтны утасны дугаар болон АТГ-ын холбогдох албан тушаалтны утасны дугаарыг мэдээллийн самбарт байрлуулан мэдээллийг чөлөөтэй авах нөхцлийг бийрүүлэн ажиллаж байна. Авлигын талаарх сурталчилгааны материалыг коридор, байцаагч нарын өрөө тасалгаанд байршуулсан.

2017 оны 01 сарын 18-ны өдөр ЭБАТ Б.Оюунтуяа хэлтсийн нийт албан хаагчдад УИХ-ын хууль зүйн байнгын хорооны 2017 оны 01 сарын 03-ны өдрийн 01 тоот тогтоолоор баталсан цахим системд ХАСХОМ-ийг үнэн зөв мэдүүлснийг батлах баталгааны маягт болон ХАСХОМ-ийг мэдүүлэхэд анхаарах асуудлын талаар сургалт зохион байгуулсан.

ТЕГ-ын 2017 оны 10 сарын 20-ны өдрийн 03/2938 дугаар чиглэл өгөх тухай албан бичгийн хүрээнд Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1дэх хэсэгт заасан нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулан бүх албан хаагчдад тухайн чиглэлийг танилцуулан гарын үсэг зуруулж 2017 оны 11 сарын 03-ны өдөр Авлига ашиг сонирхлын зөрчилөөс урьдчилан сэргийлэх, Авлигын гэмт хэрэгт өртөхгүй байх талаар сургалтыг ТУБ ЭБАТ Б.Оюунтуяа явуулсан.

Мөн АТГ-ийн Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтэст 2 удаа сургалт авахаар хандсан боловч өгөх боломжгүй гэсэн хариу өгсөн.

Албан хаагчдын сургалтанд хамрагдсан байдал:

Зохион байгуулагч	Зохион байгуулсан сургалтын тоо	Сургалтанд хамрагдсан албан хаагчдын тоо
Сангийн яам	2	9
Сургалтын төв	4	58
ТЕГ	4	9
Бусад	4	39
Нийт	14	115

Шагнал урамшуулал:

Тус хэлтсийн захиргааны тасгийн дарга татварын улсын ахлах байцаагч Т. Мандах “Санхүү банкны тэргүүн”, захиргааны тасгийн хүний нөөцийн мэргэжилтэн татварын улсын байцаагч Д. Батхуяг “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”, татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагч М. Болортуяа “Сангийн яамны жуух бичиг”, татварын орлогын тасгийн татварын улсын байцаагч Б. Ганзориг “Татварын ерөнхий газрын жуух бичиг”, татварын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч Г. Баттулга “Сангийн яамны жуух бичиг”, Б. Даваасүрэн “Татварын ерөнхий газрын хүндэт тэмдэг”, татварын орлогын тасгийн татварын улсын байцаагч Т. Оюунчимэг “Сангийн яамны жуух бичиг”, татварын орлогын тасгийн татварын улсын байцаагч С. Цэендолгор “Санхүү банкны тэргүүний ажилтан цол тэмдэг”, татварын орлогын тасгийн татварын улсын байцаагч Н. Энхээ “ Сангийн яамны жуух бичиг”, хувь хүний татварын тасгийн татварын улсын байцаагч Ж. Сайнсанаа “Сангийн яамны жуух бичиг”, эрсдэл статистикийн тасгийн татварын улсын байцаагч Б. Баярцэцэг “Сангийн яамны жуух бичиг”-ээр хийсэн ажлаараа хамт олноо хошуучлан, эрхэлсэн ажилдаа амжилт гарган тус тус шагнагдсан.

Мөн чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 25 жилийн ой, Монгол улсад шинэ үеийн татварын алба үүсч хөгжсөний 26 жилийн ой, “Үндэсний татварын ажилтны өдөр”-ийг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа идэвх санаачлагатай, үр бүтээл, итгэл зүтгэл гарган ажиллаж ирсэн Татварын хэлтсийн албан хаагчид Чингэлтэй дүүргийн 25 жилийн ойн медалиар шагнагдсан.



Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажил:

Төрийн захиргааны албан хаагч бүртэй 2017 оны үр дүнгийн гэрээ, төрийн үйлчилгээний албан хаагч бүртэй хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулж, ТЕГ-ын даргын 2016 оны Б/155 дугаар тушаалаар батлагдсан ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн хэлтсийн даргын 2017 оны 02 сарын 24-ний өдрийн А/09 дүгээр тушаалаар “Ажил үүргийн хуваарь”-ийг баталж, мөрдөн ажиллаж байна.

Татварын албаны ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах цогц төлөвлөгөөний төсөлд албан хаагчдаас санал авч нэгтгэн ТЕГ-ын ТЗУГ-т 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр хүргүүлсэн.

Монгол улсын ЗГ-ын 2011 оны 344 дүгээр тогтоолоор батлагдсан “Татварын улсын байцаагчид ажлын үр дүнгийн шагнал олгох журам”, ТЕГ-ын даргын 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/48 дугаар тушаалаар батлагдсан “Татварын улсын байцаагчийн ажил үүргийн биелэлтийг дүгнэх журам”, ТЕГ-ын даргын 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/88, 2017 оны

07 сарын 04-ний өдрийн А/134 дүгээр тушаалын дагуу төрийн захиргаа, төрийн үйлчилгээний албан хаагчдад улирал бүр үр дүнгийн шагналыг олгох журмын хүрээнд татварын улсын /ахлах/ байцаагч, ажилтнуудын 2017 оны 1-3, 4-6 7-9 дүгээр сарын ажлын үр дүнг журмын дагуу тооцож дүгнэн 2, 3, 5, 6, 10 дугаар сарын үр дүнгийн урамшууллыг олгосон.

Тус хэлтсийн Төрийн албан хаагчдаас Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв шинээр авах 11, зэрэг дэв ахиулах 32 нийт 43 татварын улсын /ахлах/ байцаагчдын нэрсийг гарган 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдөр 1/566 тоот албан бичгээр ТЕГ-ын ТЗУГ-ын холбогдох албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлүүлсэн. ТЕГ-ын даргын даргын 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/75 дугаар тушаалын дагуу зэрэг дэв ахиулах 10, шинээр олгуулах 11 албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдлийг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгохоор шийдвэрлэсний дагуу олгож байна.

Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон “Хөдөлмөрийн дотоод журамд”-д заасны дагуу 2017 оны ээлжийн амралтын хуваарийг хэлтсийн даргын 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн Б/40 дүгээр тушаалаар баталж, хуваарийн дагуу албан хаагчдын ээлжийн амралтыг эдлүүлсэн.

Тус Татварын хэлтэс нь энэ оны 3 дугаар сараас НЗЗ-ны III байрнаас нүүж сэрүүлэг констракшн ХХК-ийн Оранж плаза төвийн 1-3 давхарыг түрээслэн үйл ажиллагаагаа явуулах болсон. Ажилтан албан хаагчдын ажиллах нөхцөл сайжирсны зэрэгцээ татвар төлөгчид татварын үйлчилгээг нэг цэгээс хүндрэл чирэгдэлгүй, тав тухтай орчинд түргэн шуурхай үзүүлэх нөхцлийг бүрдүүлсэн.

Албан хаагчдын хэвийн аюулгүй орчинд ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэлтсийн хэмжээнд 6 ширхэг камерийг байршуулсан.



Албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих ажил:

МУ-ын хүн амын хэт таргалалт, түүнтэй холбоотой үүсэж буй аливаа өвчин эмгэг, нийгмийн харилцааны бэрхшээл болоод хөдөлгөөний дутагдал, халдварт бус өвчлөлийн тархалтыг багасгах, урьдчилан сэргийлэх зорилгоор “Golden gym” фитнес клубтэй 2017 онд хамтран ажиллах гэрээ байгуулсан.

2017 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр 50-р сургуулийн спорт зааланд хэлтсийн нийт албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг хөгжүүлэх зорилготой гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулсан.

2017 оны 04 сарын 17-ны өдөр 1/879 тоот албан бичгээр “Н. Нямдаваагийн нэрэмжит хавдар судлалын үндэсний төвийн эрдэм шинжилгээ, сургалтын албанд” хэлтсийн албан хаагчдын эрүүл

мэндийн боловсрол мэдлэгийг нэмэгдүүлэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл зөвлөгөө авах зорилгоор хамтран ажиллах санал хүсэлт тавьсан.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 11 дугаар тогтоолоор “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамруулах журам” батлагдсан. Энэхүү журмын дагуу үзлэг, оношилгоонд “Евростандарт эмнэлзүйн лаборатори”-той хамтран ажиллаж 2017 оны 11 сарын 03-ны өдөр хэлтсийн байранд журманд заасан насны 15 албан хаагч 3 багцаас сонгон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамрагдсан.

Халдвар судлалын үндэсний төвтэй хамтран томуугийн эсрэг вакцинд албан хаагчдыг хамруулсан.

Ази-Фарм ХХК-тай хамтран 2017 оны 12 сарын 15-ны өдөр хэлтсийн 60 албан хаагчдад эмийн хэрэглээний талаар зөвлөгөө өгөн, даралт болон сахарын шинжилгээ авч, Ази-Фармаар үйлчлүүлэх хөнгөлөлтийн картыг хамрагдсан албан хаагчдад олгосон.



Албан хэрэг хөтлөлт:

“Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, “Албан хэрэг хөтлөлтийн архив”, “Баримт бичгийн стандарт”-ыг мөрдөн хэлтсийн хэмжээнд ирсэн явуулсан бичиг, өргөдөл, гомдол, дээд газрын тушаал, шийдвэр, татварын хэлтсийн даргын тушаалыг бүртгэн, шийдвэрлэлтэнд нь хяналт тавин ажиллалаа. Мөн байгууллагын албан бичиг, тушаалын хэвлэмэл хуудсыг захиалан хэвлүүлэх, үнэт цаасыг захиалах, хадгалах, хүргүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Тус хэлтэст 2017 оны 12 сарын 28-ны өдрийн байдлаар цаасаар 2557, сүлжээгээр 1185 албан бичиг ирснийг хүлээн авч ангилан, бүртгэл хяналтын дэвтэрт бүртгэн, удирдлагаар цохолт хийлгэн хуулбарлан, хариуцан шийдвэрлэх ажилтанд шилжүүлэн ажилласан. Мөн хэлтсийн албан хаагчдын 78 өргөдөл гомдлыг шийдвэрлүүлэн ажилласан. Хэлтсийн даргын А тушаал 90, Б тушаал 100 нийт 190 тушаал гарсан байна.

2017 оны 09 сарын 11-ний өдөр Edoc программын ашиглалтын талаар сургалт зохион байгуулж бүх албан хаагчдыг хамруулан байгууллагын бүтцийг үүсгэн нэвтрэх нэр, нууц үгийг олгосон. Хэлтсийн хэмжээнд Edoc программыг бүрэн ашиглаж байна. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудтай Edoc программаар албан бичгийг хүлээн авч, шийдвэрлэн ажиллаж байна.

2017 оны 12 сарын 28-ны өдрийн байдлаар нийт бичиг 880 албан бичиг ирсэн шийдвэрлэсэн байна.

Архивын ажил:

2017 оны 02 сарын 8-ны өдрийн "Архив албан хэрэг хөтлөлтийн ажлын арга зүй, зохион байгуулалт" сургалтаар өгсөн зөвлөмж мөн НТГ-ын даргын 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн “Дүүргийн татварын хэлтсийн захиргааны тасгийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа

үзүүлэх” ажлын хүрээнд хийгдсэн ажлын зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган, анхааран ажиллаж байна.

Хэлтсийн архив бичиг хэрэг хөтлөлтийн заавар журмыг мөрдөн архивын сан хөмрөг үүсгэх зэрэг үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- 1.Хэлтсийн даргын 2016 оны нийт 156 А, Б тушаалыг цахим хэлбэрт оруулж, тоон тайланг гарган Нийслэлийн архив болон дүүргийн архивт 2017 оны 04 сарын 24-ний өдөр хүлээлгэн өгч акт үйлдүүлэн авсан.
- 2.2016 оны нийт 135 баримтыг 2017 оны 1-р улиралд архивын баримт хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байцаагчдаас хүлээн авч байршуулсан.
- 3.Хэлтсийн архиваас 2017 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар байцаагч нарт 268 хавтас бүхий баримт олгож 252 хавтаст баримт буцаан авсан.Үүнээс 219 хавтаст баримт нь хяналт шалгалтын акт болно.
- 4.Хэлтсийн архиваас шүүх цагдаад шалгагдаж байгаа шаардлагатай баримтыг тухайн он цагаар нь хайх, мөн шаардлагатай тохиолдолд байцаагч нарт 70 жил, түр хадгалах, байнга хадгалах баримтыг тус тус олгож ажилласан.
- 5.Байцаагч нарт баримт бичгийг хэрхэн стандартын дагуу үдэж хавтаслан хүлээлгэн өгөх талаар арга зүйн зөвлөгөө өгсөн.
- 6.Ажлын байрны нөхцөл сайжруулсантай холбоотойгоор хэлтсийн архивыг нүүлгэн эмхэлж, цэгцэлж баримтанд дугаар өгч дууссан.
- 7.2017 оны 04 сарын 03-ны өдрөөс тус оны 05 сарын 03-ны өдрийг хүртэлх хугацаанд хэлтсийн архивын ажилтан Архивын ерөнхий газрын дэргэдэх мэргэжил арга зүйн төвөөс явуулдаг “Архив албан хэрэг хөтлөлт”-ийн мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан.
- 8.Нийслэлийн засаг даргын 2017 оны А/688 дугаар захирамж гарч Архивын баримтын нэгдсэн тооллогыг 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 26-ны өдрийн хооронд зохион байгуулах захирамжийн дагуу Хэлтсийн даргын 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/75 дугаар тушаалаар комисс томилон тоо мэдээг цаг тухай бүрт нь дүүргийн архивын газарлуу явуулж программд бүртгэн архивын тооллогыг хийж дууссан.

1.2. Санхүүгийн үйл ажиллагааны талаар

ЧД-ийн Татварын хэлтэс нь төрийн сан дахь төсвийн, болон нэмэлт санхүүжилтийн гэсэн 2 данстайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Төсвийн дансандаа СЯ-аас хуваарилж буй урсгал санхүүжилтийг, нэмэлт дансандаа урсгал санхүүжилтээс бусад төрөл бүрийн төвлөрсөн арга хэмжээний санхүүжилтийг төвлөрүүлэн зохих журмын дагуу зарцуулан ажиллаж байна. Тус хэлтэс нь 2017 онд 1,267,966,000 төгрөгийн төсөвтэй үйл ажиллагаагаа явуулахаар батлагдсан ба нэмэлт санхүүжилтын дансанд ЧДЗДТГ-аас 98,560,551 төгрөгийн санхүүжилт авснаас Орон тооны бус байцаагч нарын цалинд 55,044,652 төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 38,752,300 төгрөг, УБ Авто зам хөгжлийн газраас АТБӨЯХАТ-ын цалин, бусад зардалд 11,779,463 төгрөгийн санхүүжилт аван 10,871,564 төгрөгийн зардал гүйцэтгэлээр гарсан. Нийгмийн даатгалын сангаас тэтгэмжинд 19,737.4 мянган төгрөгийн орлого орсон. Үнэт цаасны орлого 3,245,000 төгрөгийг төвлөрүүлсэн байна. Үнэт цаас, баримт маягтыг захиалах тооцоог хөтөлж , үнэт цаас бичиж байгаа байцаагч бүрт карт нээн хяналтыг хийж, ТЕГ-тай сар бүр тайлан тооцоо нийлж ажилласан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14.2.4-ийн “Үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасч шилжүүлэх, устгах саналаа Төрийн өмчийн хороонд тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах” заалтыг үндэслэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 02 сарын 14-ний өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу НТГ-аас ирсэн 463,497.25 төгрөгийн 2 ширхэг компьютер, ТЕГ-аас 1,140,062.58 төгрөгийн 1 ком тавилга, ЧД-ийн ИТХ-ын 2016 оны 12 сарын 09-ний өдрийн 13 дугаар тогтоолоор 2017 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрийн хүрээнд Нэг цэгийн үйлчилгээний танхимыг тохижуулах, түрээсийн байрны засварын ажилд 20,000,000.00 төгрөг, хэлтэст шаардлагатай тавилга тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд Нэг цэгийн үйлчилгээний танхимд 9,942,570 төгрөгийн тавилга эд хогшил, татварын улсын байцаагч нарт 19,999,985.75 төгрөгийн нийт 17 ширхэг Dell Optiplex 3046MT /i3, montior Dell 18.5/ компьютер, Японы Жайка байгууллагын тусламжаар 40 ширхэг Dell Optiplex 3050 суурин компьютер хүлээн авч, хөрөнгийг орлого авч бүртгэсэн. Мөн 3000,000 төгрөгийн Татвар төлөгчдийг бүртгэх мэдээллийн программыг орлого авч бүртгэсэн. 2017 оны хагас жилийн тооллогыг хийх комисс 2017 оны 11 сарын 29-ний өдрийн А/89 дүгээр тушаалаар томилогдон Хэлтсийн жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хийж дууссан.

2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах Нийслэлийн аудитын газраас ирүүлсэн албан шаардлагын хариуг 2017 оны 06 сарын 08-ны өдрийн 1/1512 тоотой хугацаандаа хүргүүлж, зөрчлийг арилгаж ажилласан.

Нийслэлийн Аудитын газраас хийсэн аудитын шалгалтаар 2016 оны 12 сарын 31-ний жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд нь холбогдох хууль, УСНББОУС, заавар журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв шударга илэрхийлэгдсэн “Зөрчилгүй санал дүгнэлт” -тэй гарсан. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 02-р сарын 14-ний өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу НТГ-аас ирсэн 463,497.25 төгрөгийн 2 ширхэг компьютер, ТЕГ-аас ирсэн 1,140,062.58 төгрөгийн 1 ком тавилгыг эд хариуцагчаар нь салган бүртгэж хөрөнгийн хадгалалт хамгаалалтанд хяналт тавин ажиллаж байна.

1.3. Хууль эрх зүйн үйл ажиллагааны талаар

Хэлтсийн даргын тушаал шийдвэрийг Монгол улсын хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт тавьж, албан тоот, гэрээ, хэлцэл, эрх зүйн баримт бичгийн төслийг хуульд нийцүүлэх ажлын хүрээнд хэлтсийн даргын 190 тушаалыг хянаж хуульд нийцүүлж, хэлтсээс бусад байгууллага албан тушаалтанд гаргасан 78 албан тоотуудыг хянаж, татвар төлөгчид болон бусад байгууллагуудаас ирсэн албан бичигт хуулийн дагуу хугацаанд нь хариу хүргүүлэн ажиллаж байна.

2017 оны эхний 2 дугаар улирлын байдлаар Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн урьд онуудын болон ТЕГ-аас хяналт шалгалт хийсэн дүгнэлтүүдийн судалгааг цэгцлэн гаргаж өнөөдрийн байдлаар нийт урьд оны 68 ААН байснаас шийдвэрийг гаргуулан авч энэ онд 32 ААН-ийн судалгааг шинэчлэн гаргаж, цагдаа, прокурорын байгууллагаар шийдвэрлүүлэхээр улирал тутам ЦЕГ-ын МБГ-ын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн мөрдөн байцаагч нараас хэргийн явцын талаар мэдээлэл авч, НПГ, дүүргийн прокурорын газрууд, ЦЕГ-ын МБГ-ын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс зэрэг байгууллагуудад албан бичиг хүргүүлж, шаардлагатай мэдээлэл авч ажиллаж байна. Үүний үр дүнд 4 эрүүгийн хэрэг үүсгэсэн газрын Өршөөлийн хуульд хамруулан

хэрэгсэхгүй болсон тогтоолыг гардан авсан. Татварын өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу дүгнэлт бичигдсэн хэргүүд хэрэгсэхгүй болж байгаатай холбогдуулан байцаалт өгч хэргийн материалтай танилцаж байна. Улсын байцаагчийн 17 сая төгрөгнөөс дээш үнэ бүхий 17 актын, ТУБ-ын бичсэн 4 дүгнэлтийн хууль зүйн үндэслэлийг хянаж зөвлөгөө өгсөн болно.

Мөн Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан хэрэг маргааны хувьд Жанхарцамхаг ХХК-д давж заалдах болон захиргааны журмаар, Есөн талст оргил костракшн ХХК-ийн хувьд давж заалдах журмаар, “Булбул”-ийн хувьд анхан шатны журмаар, “Махаяна уламжлалыг хадгалах төв”-ийн нэхэмжлэлтэй хэрэгт анхан шатны шүүх хуралд оролцсон. Мөн “Ордос” ХХК, “Аж богд трейд” ХХК анхан болон давах, Дүүрэн трейд ХХК, Мөнхболор ХХК-ийн хуралд мөн оролцож татварын албаны талд шийдвэрлүүлсэн байна. Кингсаплай ХХК-ийн анхан, давах, хяналтын шатны журмаар шийдвэрлэсэн шүүх хуралдаанд оролцсон. Булбул ХХК болон Тэнүүнбайгль ХХК-ын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг нь захиргааны хэргийн шүүх дээр хянагдаж байна.

Татварын ерөнхий хуулийн татвар ногдуулалт, төлөлт хураалт болон хяналт шалгалтын процесс ажиллагаа хийгдсэн татварын өрийг гаргуулахаар иргэний журмаар нэхэмжлэх, татварын албаны итгэмжлэлээр Татварын ерөнхий хуулийн татвар ногдуулалт, төлөлт хураалт болон хяналт шалгалтын процесс ажиллагаа хийгдсэн татварын өрийг гаргуулах болон эрэн сурвалжлуулах, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр Иргэний журмаар нэхэмжлэх, татварын албаны итгэмжлэлээр 24 ААН-ийн 2,397,226.5 мянган төгрөгийн өрийг шүүхээр шийдвэрлүүлэхээр нэхэмжилснээс 20 ААН-ийн 1,734,194.5 мянгантөгрөгийг татварын албаны талд төлүүлэхээр шийдвэрлүүлж үлдэх 4 ААН-ийн нэхэмжлэлийн хувьд харьяаллын шүүх дээрээ ажиллагаа хийгдэж байна.

2017 онд Шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамжийн дагуу татварын өрийг сайн дураараа биелүүлээгүй татвар төлөгчийг ИХШХШ тухай хуулийн 185 дугаар зүйлд зааснаар албадан гүйцэтгэх хуудас бичүүлж, Банк хадгаламж зээлийн хоршооны төлбөр барагдуулах ажлын албатай шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Хууль зүйн сайдын 2013 оны А/181 дүгээр тушаалыг үндэслэн татварын албаны итгэмжлэлээр гэрээ байгуулан 2017 онд 8 ААН-ийн 522,252,088.6 төгрөгийн өрийг барагдуулуулахаар нэмж өгч нийт 63 ААН-ийн 4,262,489.34 мянган төгрөгөгийнөрийг барагдуулахаар ажиллагаа хийгдэж байна. Шийдвэр гүйцэтгэгч нартай хамтран ажиллаж гүйцэтгэх ажиллагааны явцтай танилцаж, 2017 онд нэмж өгсөн ААН-ийн 10 сая төгрөгөөс дээш өртэй ААН-ийн захирлуудад хилийн хаалт хийлгэж, ажлын байр болон гэрийн хаягаар шийдвэр гүйцэтгэгч нартай хамт очиж өр барагдуулах ажиллагааг эрчимжүүлэн 23 ААН-ийн өрийг хэсэгчлэн барагдуулан нийт 469,942.63 мянгантөгрөгийн өрийг барагдуулан ажиллалаа.

ХОЁР. ТАТВАР ТӨЛӨГЧИЙН БҮРТГЭЛ БОЛОН ТАЙЛАН ХҮЛЭЭН АВАЛТЫН

АЖЛЫН ХҮРЭЭНД:

2.1.Татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх, татварын хууль тогтоомжийг сурталчилах, татварын боловсрол олгох, зөвлөгөө өгөх ажлын талаар

Татвар төлөгчдийг ая тухтай үйлчлүүлэх боломжоор хангахын тулд ТЕГ-ын Татвар төлөгчдөд үйлчлэх газраас хэрэгжүүлж буй "Нэг цэгийн үйлчилгээ - Нэг өнгө төрх" ажлын хүрээнд татвар төлөгчдийг ая тухтай, түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүй үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэн, утсаар болон биечлэн заавар зөвлөгөө өгч, татвар төлөгчдийн цахим булангаар татвар төлөгчдөд зөвлөгөө өгөн ажиллаж байна.

2017 оны сурталчилгааны төлөвлөгөөний дагуу томоохон худалдааны төв захуудад зөвлөгөөний төв ажиллуулан сурталчилгаа хийх, АТБӨЯХАТ-ыг хураахтай холбогдон сурталчилгаа хийх, Татварын хууль тогтоомж, түүнд орсон өөрчлөлт, татварын албаны үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, радио телевизээр сурталчлах ажлыг зохион байгууллаа.

Татвар төлөгчдөд үйлчлэх нэг цэгээр биечлэн 52000 гаруй, утсаар 41600 татвар төлөгчдөд зөвлөгөө өгч ажиллалаа.

Д/Д	Үзүүлсэн үйлчилгээ		Татвар төлөгчийн тоо
1	Зөвлөлгөө өгсөн	Утсаар	57600
		Биечлэн	48200
2	Татвар төлөгчдөд мэдээлэл хүргэсэн	Масс мессежээр	20000
		НТА.МН	20
		Бусад	400
3	Сургалт, сурталчилгаа	Сургалт хийсэн	87
		Сургалтанд хамрагдсан ТТ-ийн тоо	9393
		Шинээр сурталчилгааны материал бэлтгэсэн	3
		Гарын авлага, тараах материал тараасан тоо	15000
		Хэвлэл мэдээллээр хийсэн сурталчилгааны тоо	3
	Радио телевизээр сурталчилгаа хийсэн	14	

2017 оны төлөвлөгөөний дагуу нийт 97 удаагийн сургалт явуулснаас ААН, иргэн, худалдааны төвүүдэд 84, ТББ 2, ирээдүйн татвар төлөгчдөд 10, их дээд сургууль 2 удаагийн сургалтыг тус тус зохион байгуулсан байна.

Хаана	Зохион байгуулсан сургалтын тоо	Хувь
ААН, иргэн, худалдааны төвүүдэд	84	86,5%
Ирээдүйн татвар төлөгчдөд	10	10,3%
Их дээд сургуулиудад	2	2,1%
ТББ-т	1	1,1%

2.2. Татвар төлөгчийг бүртгэх, бүртгэлийн мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн сангийн үнэн зөв байдлыг хангах талаар

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн улсын бүртгэлд шинээр бүртгэгдсэн 958 аж ахуйн нэгж, 203 төсөвт болон төрийн бус байгууллага нийт 1161 аж ахуйн нэгж, байгууллагыг татвар төлөгчөөр бүртгэж, 252 хуулийн этгээдийн нэмэлт, өөрчлөлтийг хийж, 226 татвар төлөгчийн шилжилт хөдөлгөөнийг, шилжиж ирсэн 9 аж ахуйн нэгжийг журмын дагуу бүртгэсэн.

Татвар төлөгчийн бүртгэлийн өөрчлөлтийг 2017 оны 12-р сарын 28-ны өдрийн байдлаар харуулбал:

Төрөл	2017.01.01-ний байдлаар	Нэмэгдсэн	Хасагдсан	2017.12.28-ны байдлаар
ААН	13437	1099	82	14454
Төсөвт болон ТББ	2436	254	21	2669
Нийт	15873	1353	103	17123

Тайлант хугацаанд нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн босго давсан, е-баримтаар борлуулалтын орлого 50,0 сая, төгрөгнөөс дээш давсан бүртгүүлбэл зохих иргэн, аж ахуйн нэгж бүртгэхээс 143 иргэн, аж ахуйн нэгжийг бүртгэж гэрчилгээ олгосон байна.

НӨАТ төлөгчийн хөдөлгөөний мэдээг 2017 оны 12 сарын 28-ны өдрийн байдлаар харуулбал:

Хариуцлагын хэлбэр	2017.01.01-ний бадлаар	Нэмэгдсэн	Хасагдсан	2017.12.28-ны байдлаар
ААН	3186	224	201	3209
Иргэн	54	12	3	63
Бүгд	3240	236	204	3271

2016 онд үйл ажиллагаа явуулаагүй 12 сар Х тайлан гаргасан 772 аж ахуйн нэгж, иргэнд эрсдэл тооцуулахаар эрсдэлийн удирлагын тасагт шилжүүлж, тайлант хугацаанд 34 татвар төлөгчийг бүртгэлээс хасаж, тушаалаар баталгаажуулсан байна. Тусгай зөвшөөрөлтэй, зөвшөөрөл шинээр авсан 58 аж ахуйн нэгжийг нийслэл хотын албан татвар төлөгчөөр бүртгэсэн.

НХАТ төлөгчийн хөдөлгөөний мэдээг 2017 оны 12 сарын 28-ны өдрийн байдлаар харуулбал:

Татвар төлөгч	2017.01.01-ний байдлаар	2017.12.28-ны байдлаар	Өсөлт, бууралт /+,-/
ААН	525	585	/+60/
Иргэн	85	82	/-3/
Бүгд	610	667	/+57/

хүснэгтээр харуулбал:

Татвар төлөгч		2017.01.01-ны өдрийн байдлаар	Нэмэгдсэн	Хасагдсан	2017.12.28-ны өдрийн байдлаар
А. АТБӨЯХАТ	Бүгд	37970	1734	8	39696
	Үүнээс: - ААНБ	2013	66	2	2077
	-иргэн	35957	1668	6	37619
Б. ҮХЭХАТ	Бүгд	1542	134	62	1614
	Үүнээс: - ААНБ	627	27	25	629
	-иргэн	915	107	37	985
В. Галт зэвсэгийн албан татвар	Бүгд	812	46	47	817
	Үүнээс: - ААНБ	41	2	3	40
	-иргэн	37970	1734	8	39696

2017 онд нийт 117 үл хөдлөх хөрөнгийг шинээр бүртгүүлэн бааз суурийг нэмэгдүүлсэн. ҮХЭХ-ийн албан татварын бааз суурийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд тооллогын ажил зохион байгуулан хороод дээр ажиллаж байна.

2.3. Татварын тайлан хүлээн авах, ногдлыг хянах, баталгаажуулалт хийх, суутган тооцоолол, буцаан олголтын бичилт хийх талаар

Татвар төлөгчөөс ирүүлбэл зохих бүх төрлийн татварын тайланг журмын дагуу хүлээн авч, татварын тайлангийн эхний үлдэгдэл болон тайлангийн хугацаанд төлсөн татварыг тулган баталгаажуулж, алдаатай тайланг татвар төлөгчдөд буцаан, татвар төлөгчийн хүсэлтээр залруулж ажиллалаа.

Татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллагуудаас гаргаж ирүүлбэл зохих бүх төрлийн татварын тайланг ТЕГ-аас баталсан татварын тайлан хүлээн авах журмын дагуу татвар төлөгчдийг чирэгдүүлэхгүй, дараалал үүсгэхгүйгээр хүлээн авч, татварын тайлангийн эхний үлдэгдэл болон тайлангийн хугацаанд төлсөн татварыг тулган баталгаажуулж, алдаатай тайланг татвар төлөгчдөд буцаан, татвар төлөгчийн хүсэлтээр залруулж ажиллалаа.

2016 оны төлөлт, ногдуулалтыг үндэслэн бусад татвар, төлбөр, хураамжийн ногдуулалтыг баазад оруулсан байна.

Тайлан хүлээн авалт:

Тайлангийн төрөл	Хүлээн авсан тайлангийн тоо
ААНОАТТ	29740
НӨАТТ	30370
Суутган-1	32682
СХХООСАТ	2581
ХХОАТТ	3356
НХАТТ	1832
Бусад албан татвар, төлбөр хураамжийн тайлан	568

2016 оны 4 улирлын байдлаар тайлангийн ирц хангуулахаар ажиллаж хадгалсан төлөвт байсан тайланг 100% дуудаж ажилласан. 2017 оны 1,2,3 дугаар улирлын хадгалсан болон шалгуур хангаагүй буцаасан тайланг дуудаж НТГ-т шилжих 226 ААН-ийн ирцийг хангуулж ажилласан. 2016 оны 4-р улирлаар болон 2017 оны хагас жилээр тэмдэгтийн хураамжийн тайлан ирүүлээгүй төрийн байгууллагуудын тайланг хүлээн авч, нөхөн тайлагнуулсан. Бусад татварын төрлөөр тухай бүр тайлангийн ирц хангуулж ажиллалаа. Хуулийн хугацаанд тайлан ирүүлээгүй 2 ААН-д торгуулийн хариуцлага тооцож ажилласан.

Ногдлын хяналтын ажил:

Хэлтсийн даргын 2017 оны 01 сарын 06-ны өдрийн А/03 дугаар тушаалын хүрээнд орон сууц сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлэхээр материалаа ирүүлсэн 289 иргэний буцаан олголтын материалыг түүвэрлэн 2015 оны хөнгөлөлт, чөлөөлөлтийн тайланд татвар төлөгчийн нотлох баримт бүрдүүлэлт, хөнгөлөлт чөлөөлөлтийн тооцоолол, буцаан олголтын илүү дутууг дахин хянаж 6 иргэнээр зөрчлийг арилгуулж ажилласан.

НӨАТ-ын хуулийн хэрэгжилттэй холбоотой ТЕГ-аас ирүүлсэн НӨАТ суутган төлөгч биш мөртлөө эцсийн хэрэглэгчид Е-баримт олгохдоо НӨАТ суутган тооцож баримт олгосон зөрчилтэй 148 татвар төлөгчөөс 92 татвар төлөгчийн олгосон е-баримтанд залруулга хийлгэж, 3 татвар төлөгч өөр дүүрэгт шилжсэн тул татварын бүртгэлээс хасуулахаар материалыг хүлээн авч бүртгэл хариуцсан байцаагчид өгсөн ба НӨАТ суутган төлөгчийн болзол хангасан 2 иргэн 4 ААН-ийг НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлэх шаардлагатайг сануулж зөвлөгөө өгч ажилласан.

2016 оны 04 дүгээр улирлын байдлаар татварыг нь суутгаагүй орлого /Суутган-12-1-2/ тайлан мэдээ ирүүлсэн 20 татвар төлөгчийн 163 иргэний зөрүүтэй мэдээллийг залруулахаар орлого олгож тайлан, мэдээ ирүүлсэн татвар төлөгчтэй холбогдож 9 иргэний 152271,1 мян/төгрөгийн үнийн дүнтэй тайланг нөхөн тайлагнуулж өөр дүүрэгт тайлан өгсөн 4 иргэнд тайлангаа залруулахыг сануулж мөн өөр дүүрэгт шилжсэн боловч хасалтаа хийлгээгүй байсан 2 иргэнийг бүртгэлээс хасууллаа. Бусад нэр регистр нь буруу иргэдийн мэдээллийг залруулуулахаар орлого олгосон байгууллагатай холбогдож ажиллалаа.

2016 оны татварын тайлан засварлахаар хүсэлт ирүүлсэн 80 татвар төлөгчийн тайлан засварлах албан хүсэлт, материалыг шалгаж тайланг засварлуулсан.

Хувь хүний татварын тасгаас ирүүлсэн Монгол банкинд алт тушаасан мэдээтэй тайлан ирүүлээгүй, тайлан ирүүлсэн хэдий ч зөрүүтэй тайлан ирүүлсэн 11 татвар төлөгч иргэний тайланг хянаж 2 иргэний 28477605,8 мян/төгрөгийн борлуулалттай 1271,5 мян/ төгрөгийн ногдолтой тайланг

нөхөн тайлагнуулж тайлагнуулж 3 иргэн нь өөр дүүрэгт тайлагнасан 1 иргэн компанийн нэр дээр тайлангаа өгсөн болохыг тодруулж ажиллалаа.

Тус дүүрэгт харьяалалтай давхардсан тоогоор 170 тайлан ирүүлээгүй иргэнээс 54 иргэнтэй холбогдож иргэний орлогын тайланг нөхөн тайлагнуулсан ба холбоо барих боломжгүй 87 иргэнийг Хувь хүний татварын тасгийн хороо хариуцсан байцаагч нарт хүргүүлж тайланг гаргуулж ирүүлэх ажлыг зохион байгуулж байна.

ТЕГ-аас ирүүлсэн цахим төлбөрийн баримтын системд борлуулалтын мэдээгээ ирүүлээгүй 71 ААН-д ногдлын хяналт хийхэд бүгд мэдээгээ илгээсэн харин худалдан авагч баримтаа шивээгүй буюу буруу шивсэн зөрчлийг арилгуулж ажилласан.

ТЕГ-ын ТХШАЗГ болон ЦЕГ-ын ЭЦА-ны ЭЗГХТХ-ээс ирүүлсэн нэмэгдсэн өртгийн албан татварын падаан тараагчдаас худалдан авалт хийсэн нэр бүхий 18 аж ахуйн нэгжийн тайланд ногдлын хяналт хийж 3924825,0 мянган төгрөгийн зөрчилд 389441,5 мянган төгрөгийн нөхөн ногдол оруулж ажилласан. Зөрчлөө хүлээн зөвшөөрөөгүй 3 ААН-ийн хяналт шалгалт хийлгэхээр дүгнэлт бичиж хобогдох нэгжид шилжүүлсэн болно.

Татвар төлөгчдийн өдрүүд-2017

Татварын албанаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Татвар төлөгчдийн өдрүүд” арга хэмжээг “**Эх орныхоо хөгжлийг бүтээгч- Эрхэм татвар төлөгч танд баярлалаа**” уриан дор 5сарын 8-12-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсэн.Энэ ажлын хүрээнд:

Ирээдүйн татвар төлөгч нарт зориулсан сургалт, уралдаан

- ЧД-ийн Татварын хэлтсийн дарга Б.Батбаяр Нийслэлийн 57-р сургуулийн 12б ангид, Захиргааны тасгийн дарга Т.Мандах Хөдөлмөрийн дээд сургуулийн 3-р курсийн оюутнуудад "Татварын тогтолцоо" ба "Би –Ирээдүйн татвар төлөгч"сэдэвтэй хичээл, Хяналт шалгалтын тасгийн дарга Л.Мөнхлут Улаанбатар эрдэм дээд сургуульд, Эрсдэл статистикийн тасгийн дарга Н.Энхсаруул 37-р сургуулийн 11а ангид, Татварын орлогын тасгийн дарга Н. Амарбаясгалан 72-р сургуулийн 12б ангид, Хувь хүний татварын тасгийн дарга Н.Түвшинцэцэг 24-р сургуулийн 11а ангид, Татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга Л.Болормаа 17-р сургуулийн 12а ангийн сурагчдад "Би ирээдүйн татвар төлөгч" сэдэвт хичээл зааж нээлтийн арга хэмжээг эхлүүлсэн.



- ТЕГ-аас “Татвар төлөгчдийн өдрүүд”-ийн хүрээнд “Татвар төлөгч танд баярлалаа”сэдэвт гар зураг, зохион бичлэгийн уралдааныг ЕБС-ийн сурагчдын дунд 2017 оны 4 сарын 10-24-ний өдрийг хүртэл хугацаанд зарласан.

Гар зургийн уралдаанд:

- ❖ 1 дүгээр байр - 23-р сургуулийн 9Г ангийн сурагч М.Байгал
- ❖ 2 дугаар байр - 37-р сургуулийн 11Г ангийн сурагч Г.Хулан
- ❖ 3 дугаар байр - 5-р сургуулийн 12Б ангийн сурагч О.Энх-ундрах нар тус тус эзэлсэн.

Зохион бичлэгийн уралдаанд:

- ❖ Тэргүүн байр - 17-р сургуулийн 12Г ангийн Д.Сугармаа
- ❖ Дэд байр - 17-р сургуулийн 10В ангийн сурагч С.Отгон-эрдэнэ
- ❖ 3-р байр - 72-р сургуулийн 12В ангийн сурагч Б.Оюунтуул
- ❖ Тусгай байр - 117-р сургуулийн 8А ангийн сурагч Т.Энхчимэг, 23-р сургуулийн 9Г ангийн сурагч М.Байгал, 117-р сургуулийн 7А ангийн А.Анулин нар тусгай байр тус тус эзэлж амжилттай оролцлоо.

Амжилттай оролцож дүүрэгтээ байр эзэлсэн сурагчид болон нийт оролцсон сурагчдад өргөмжлөл, талархалгардууллаа. Татвар төлөгчдөд татвар төлөгчдийн өдрүүдийг таниулан сурталчилах үүднээс хэлтсийн байр болон нэг цэгийн үйлчилгээний байрыг чимэглэн гар зургийн уралдаанд оролцсон нийт бүтээлүүдээр үзэсгэлэн гаргасан.



Их дээд сургуулийн оюутнуудад зориулсан сургалт, семинар, хэлэлцүүлэг

- ЧД-ийн нутаг дэвсгэрт байрлах “Улаанбаатар Эрдэм дээд сургууль”, “Хөдөлмөр-Нийгэм Харилцааны Дээд сургууль”-ийн эдийн засгийн тэнхимийн 3 дугаар курсын 150 гаруй оюутнуудад “Татварын тогтолцоо” сэдвээр сургалт, семинар, хэлэлцүүлэг зохион байгууллаа. Уг сургалтын явцад оюутнууд татварын байгууллагын ажлын онцлог, шинээр хэрэгжиж буй НӨАТУС, Ebarimt.mn сайтын талаар асууж харилцан ярилцан мэдээлэл солилцлоо.



- Их, Дээд сургуулиудын оюутнуудын дунд ТМЗ нийгэмлэгтэй хамтран зохион байгуулагддаг “Татварын тухай хуулийг хэн сайн мэдэх вэ?-2017” асуулт хариултын тэмцээнийг зохион байгуулж ажилласан. 2017 оныэнэудаагийнаргахэмжээнд Чингэлтэйдүүрэггүйлажиллагааявуулдагхдээдсургуулиудын төлөөлөл болж “Улаанбаатар эрдэм Оюу” дээд сургууль оролцож шагналт 4-р байр эзэлсэн. Мөн “Улаанбаатар эрдэм оюу” дээд сургуулийн оюутнуудтай хамтран “Хүчит шонхор” зах дээр ebarimt-ын талаар танилцуулга сурталчилгааны өдөрлөг зохион байгуулж ажилласан.



Бизнес эрхлэгч, татвар төлөгчдөд зориулсан сургалт, сурталчилгаа, зөвөлгөө

- ЧДЗДТГ-ын хурлын танхимд 2017 онд шинээр үүсгэн байгуулагдсан 116 аж ахуй нэгжүүдэд, жижиг дунд үйлдвэрлэгч аж ахуй нэгжийн нягтлан бодогч, менежерүүдэд татварын ерөнхий хууль, шинээр хэрэгжиж буй хууль тогтоомж, татварын тайлан хэрхэн гаргах, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны сургалтыг хийсэн.



- Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Татвар төлөгчдийн өдрүүдийн ажлын хүрээнд Шилдэг татвар төлөгчдийн дунд VTV телевизийн QUIZ цэнгээнт нэвтрүүлэгт 6 аж ахуй нэгжийн төлөөллийг оролцуулсан.Цэнгээнт нэвтрүүлэгт ЧД-ийн Шилдэг татвар төлөгчдийн төлөөлөл болох “Арина электроникс” ХХК, “Сэрүүлэг констрашн” ХХК, Дүүргийн найдвартай татвар төлөгч “Ренталлон” ХХК, “Дакал фарм” ХХК,Нийслэлийн шилдэг татвар төлөгч“Блю скай” ХХК, “Цэц зам плаза” ХХК-ны төлөөлөлүүд оролцож “Арина электроникс” ХХК-ны менежер тэмцээний ялагч болсон.
- Чингэлтэй дүүргийн 19 хорооны иргэний танхимд “Татвар төлөгчдийн өдрүүд”-ээр хороодын ахмадууд болон иргэдэд Ebarimt-ийг шивж өгч, иргэд ААН-д татварын хуулиудын шинэчлэл, өөрчлөлт болон цаг үетэй холбоотой асуудлаар мэдээлэл өгч ярилцан холбогдох асуултанд хариулт өглөө. Уг уулзалт ярилцлагад нийт 435 ААН иргэдийн төлөөлөл оролцсон бөгөөд 2000 гаруй татварын хуулийн танилцуулга, тараах материал, ном товхимол тарааж ажилласан.



- ЧД-ийн 1-р хороонд Худалдаа үйлчилгээний хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Хөдөлмөрийн хэлтэс, Халамж үйлчилгээний хэлтэс, Прокурорын байгууллага, Өрхийн эрүүл мэндийн төв, Чингэлтэй ТҮК зэрэг төрийн байгууллагууд оролцож иргэд, ААНБ-д шаардлагатай мэдээлэл өгч хамтран ажилласан.



- ЧД-ийн хүн амын төвлөрөл ихтэй томоохон 8 худалдааны төвд 20 байцаагч 1240 худалдаа эрхлэгч ААН иргэдэд татварын хууль тогтоомжийгтаниулан сурталчилж сургалт зохион байгуулж зөвлөгөө өгч ажиллалаа.



Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажилласан байдал

- Монгол HD телевизийн “Өнөө өглөө” хөтөлбөрөөр 2017 оны 05 сарын 08-11-ний өдрүүдээр

Татварын улсын ахлах байцаагч Н. Түвшинцэцэг “ХХОАТ”-ын талаар,

Татварын улсын ахлах байцаагч Л. Болормаа “Татвар гэж юу вэ?, Татварын тухай ойлголт”-ын талаар

Татварын улсын байцаагч Б. Бат-Эрдэнэ “НӨАТУС”-ийн талаар

Татварын улсын байцаагч Б. Мөнхтулга “АТБӨЯХАТ”-ын талаар иргэдийн сонирхсон асуултанд хариулж, татвар төлөгчдөд зөвлөгөө мэдээлэл өгсөн.

- 2017.05.11-ны TV8 телевизийн “Өдрийн толь” хөтөлбөрөөр ХХОАТ болон НӨАТУС-ийн талаар мэдээлэл зөвлөгөө хүргэсэн.
- 2017.05.12 ны VTV-ын “QUIZ” цэнгээнтнэвтрүүлэгт Татвар төлөгчдийн өдрүүдийн талаар болон шилдэг татвар төлөгчдийг алдаршуулах үүднээс оролцсон.
- Хамаг Монгол 95.1 радиогоор 5 сарын 11-ний өдрөөс 5 сарын 12-ний өдрүүдэд АТБӨЯХАТ-ын талаар зөвлөгөө өгөн ажилласан.
- TV ZONE сэтгүүлийн №462 дугаар дугаарын “Иргэн таны хууль, эрх зүйн мэдлэгт” хуулийн буланд “ААНОАТ-ын албан татварын тухай хууль”-ийн талаар хувь хүн, хуулийн этгээдэд мэдээлэл түгээх зорилгоор нийтлэл гарган ажилласан.
- Энэ жилийн хүрээнд 2 төрлийн брошур, 1 төрлийн зурагт хуудас, 1 төрлийн наадаг стикер нийт 4300 ширхэгийг хэвлүүлэн татвар төлөгчдөд тараан ажилласан.

Шилдэг татвар төлөгч

ТЕГ-ын даргын 2017 оны 4 дүгээрсарын 19-ны өдрийн А/84 дугаар тушаалаар батлагдсан “Шилдэг татвар төлөгчийг шалгаруулах, татвар төлөгчийг шагнаж урамшуулах журам” –ын 2.2-т заасны дагуу 31 татварын албанаас 99 татвар төлөгчийг 2016 оны шилдэг татвар төлөгчөөр шалгаруулсан.

ТЕГ-ын шилдэг татвар төлөгч аж ахуй нэгж:

1. Номинреалтор ХХК
2. Мигдаатгал ХХК
3. Сэрүүлэгконстракшн ХХК
4. Аринакомпьютерс ХХК

Нийслэлийн шилдэг татвар төлөгч иргэн:

1. Г.Батбаяр
2. Урлагийн салбарын шилдэгээр Т.Мөнх-Эрдэнэ

Нийслэл хотын албан татвар суутган төлөгч шилдэг аж ахуйн нэгж:

1. “Блюскай эйжиа” ХХК

НӨАТТХ, НХАТТХ-ийг хэрэгжүүлэх үүргээ биелүүлэн төлбөрийн Е-Баримт хамгийн их олгож хэрэглэгчээ дээдэлсэн татвар төлөгч:

1. “Азифарм” ХХК,
2. “Улаанбаатар синема” ХХК

Үндэсний шилдэг брэнд үйлдвэрлэгч:


1. Цэц зам пласт ХХК
2. Аминарайсен ХХК

Дүүргийн найдвартай татвар төлөгч аж ахуй нэгж:

1. “Ренталлон” ХХК
2. “Гламур” ХХК
3. “Дакал фарм”

Дүүргийн найдвартай татвар төлөгч иргэн:

1. Б. Цэрэнлхам
2. С. Одончимэг
3. Ц. Ганзориг



Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн Драгон төвд “Нээлттэй хаалганы өдөрлөг”

НТГ, ЧД-ийн татварын хэлтэс, “Монгол такс Татварын мэргэшсэн зөвлөх” компани, “Хэрэглэгчдийн систем нийлүүлэгчдийн холбоо” ТББ-ууд хамтран кассын машин, POS төхөөрөмжийн худалдаа, НӨАТХ, Е-баримт цахим системийн сурталчилгааг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн “Драгон” төвд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулагдлаа. Татварын албад татвар төлөгчдөд биечлэн зөвлөгөө өгөхийн зэрэгцээ кассын машин, POS төхөөрөмж нийлүүлэгч компаниудын үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдлаа.



Сангийн яамны "Нээлттэй хаалганы өдөрлөг"

Татварын албанаас 18 татварын улсын байцаагч 460 иргэнд татварын хуулиуд болон НӨАТУС, цахим төлбөрийн баримтын талаар зөвлөгөө мэдээлэл өгч, ГТСМТТ, кассын машин, POS төхөөрөмж нийлүүлэгч компаниуд 40 ААН, 260 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 1000 иргэнд танилцуулга тарааж, 1300 иргэнд үйлчилсэн байна. Мөн татварын улсын 8 байцаагч, Улаанбаатар банкны 4 теллерийн бүрэлдэхүүнтэй ажиллаж, АТБӨЯХАТ, АБТ, АЗАТ-ыг татварын алба харгалзахгүй, торгуульгүйгээр хүлээн авч, 1765 тээврийн хэрэгслээс 70,6 сая төгрөгийн албан татвар, төлбөр хураан авч орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.



ГУРАВ. ТАТВАР ОРЛОГО БҮРДҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

Татвар хураалтын ажлын түвшинг дээшлүүлэх, татварын өр барагдуулалтын ажлыг эрчимжүүлэх үндсэн дээр улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн орлогыг жигд ханган биелүүлэх зорилттой ажиллаж байна.


4.1.Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн талаар:

/2017.12.28-ны байдлаар/

(мянган төгрөг)

Татварын төрөл	Орлогын мэдээ /2017.12.28/		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Сум, дүүргийн төсөв	58,638,255.3	60,338,435.2	102.9%
Улсын төсөв	61,033,183.6	69,966,809.8	114.6%
Аймаг, нийслэлийн төсөв	64,426,360.0	68,094,513.5	105.7%
НИЙТ ДҮН	184,097,798.9	198,399,758.5	107.8%


Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 2017.12.28-ны байдлаар



Нийт төсвийн гүйцэтгэл 114,6 %-тай байна.

Улс, нийслэл, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө биелүүлэхэд хүндрэлтэй байгаа учраас төлөвлөгөөг биелүүлэх тал дээр анхааран төлөвлөгөө биелүүлэх боломжийн судалгааг хариуцсан байцаагч сар бүр аж ахуй нэгжийн тайлагнаж бүртгүүлсэн татварын төрөл тус бүрээр гарган ажиллаж байна.

ЖИГД АЖИЛЛАГАА



Төлөвлөгөөний биелэлт Татварын төрлөөр



3.2.Татварын өрийн барагдуулалтын талаар

2017 оны 12 сарын 31-ны байдлаар урьд оны нийт 68,739,466.2 мянган төгрөгийн өрийн тайлангаарх өрийн үлдэгдлээс 58.1 хувийг буюу 32,398,171.4 мянган төгрөг, хяналт шалгалтын актаар ногдуулсан өрийн 8.0 хувь буюу 1,039,641.8 мянган төгрөгийг тус тус барагдуулсан байна.

(мянган төгрөг)

Үзүүлэлт	Урьд оны өрийн барагдуулалт			
	Оны эхний үлдэгдэл (2017.01.01)	Өрийн барагдуулалат	Барагдуулалтын хувь	Оны эхний өрийн үлдэгдэл (2017.12.31)
Тайлангаарх өр	55,767,084.5	32,398,171.4	58.1%	23,368,913.0
Хяналт шалгалтаарх өр	12,972,381.7	1,039,641.8	8.0%	11,932,739.9
Урьд оны нийт өр	68,739,466.2	33,437,813.2	48.6%	35,301,653.0

Татварын хэлтсийн хэмжээнд 2017 оны 12 сарын 31-ны байдлаар албан татвар, төлбөр, хураамжийн тайлангаар нийт 162,638,593.5 мянган төгрөгийн татвар ногдсоноос 88.4 хувь буюу 143,781,324.0 мянган төгрөгийг барагдуулсан байна.

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Тайлант оны ногдлын барагдуулалт			
	Тайлант онд ногдсон	Тайлант оны ногдлын барагдуулалат	Барагдуулалтын хувь	Тайлант оны ногдлын үлдэгдэл (2017.11.30)
Тайлангаарх ногдуулсан	156,945,985.1	140,115,096.1	89.3%	16,830,889.1
Хяналт шалгалтын актаар ногдуулсан	5,692,608.3	3,666,227.9	64.4%	2,026,380.4
Урьд оны нийт өр	162,638,593.5	143,781,324.0	88.4%	18,857,269.5

Татварын өр, ногдлыг барагдуулахаар татвар хураах шат дараалсан арга хэмжээг авч Debt management буюу татварын өрийн удирдлагын программд бүртгэж байна. Тухайн татвар төлөгчийн өрийг бодуулж өрийн үлдэгдэл дүн зөрүүтэй болон программтай холбоотой алдаа, тайлбарыг хүргүүлж ажилласан.

Татварын өр барагдуулахаар ТЭХуульд заасны дагуу татвар хураах шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал:

/2017оны 12 сарын 31-ны байдлаар/

Үзүүлэлт	Өссөн дүнгээр /мян.төг/			
	Урд оны татварын өр		Тайлант оны дутуу	
	ТТТоо	Дүн	ТТТоо	Дүн
Мэдэгдэх хуудас хүргүүлсэн	1240	32,906,906.1	676	17,258,128.9
Татвар төлөгчид хүргүүлсэн мэдэгдэх хуудасны гүйцэтгэл /төсөвт орсон орлого/	536	5,221,491.8	213	2,179,358.3
Харилцах дансны зарлагын гүйлгээ хаасан	516	18,894,152.9	179	6,837,154.8
Харилцах дансны зарлагын гүйлгээ хаасны гүйцэтгэл /төсөвт орсон орлого/	195	1,885,795.9	27	851,438.7
Эд хөрөнгө, цалин хөлснөөс гаргуулах мэдэгдэх хуудас хүргүүлсэн	2	71,807.9		
Эд хөрөнгө, цалин хөлснөөс татварын өр гаргуулсаны гүйцэтгэл /төсөвт орсон орлого/	1	35,789.8		
Эд хөрөнгө барьцаалсан	9	524,996.1		200,107.5
Эд хөрөнгө барьцаалснаас төсөвт орсон орлого	8	200,746.5		100,994.5
Эд хөрөнгө битүүмжилсэн	3	109,238.4		138.0
Эд хөрөнгө битүүмжилсэнээс төсөвт орсон орлого	2	9,553.7		
Шүүхэд нэхэмжилсэн	21	2,095,509.4		
Шүүхийн шийдвэр гарсан	19	1,490,903.9		
ШШГА-д гүйцэтгэл хийгдэж байгаа татварын өр	63	4,443,566.3		
ШШГА-д гүйцэтгэл хийгдэж байгаа татварын өрөөс орсон орлого /тухайн сард	30	473,542.7		

Урьд оны болон тайлант оны өр, ногдлын 50,165,034.9 мянган төгрөгийн дутуу үлдэгдэлтэй 1433 татвар төлөгчид мэдэгдэх хуудасыг цахим шуудангаар болон биечлэн гардуулж, тухайн заасан хугацаанд өрөө барагдуулаагүй 25,731,307.6 мянган төгрөгийн өртэй 516 татвар төлөгчийн банкин дахь харилцах дансыг хаах мэдэгдэх хуудсыг арилжааны банкуудад хүргүүлэн ажиллаж байна.

ТЭХуулийн 64 дугаар зүйлийг үндэслэн 9 аж ахуй нэгжийн 727,103.6 мянган төгрөгийн татварын өрөнд харилцан тохиролцсоны үндсэн дээр татвар төлөгчийн эд хөрөнгийг барьцаалж, эд хөрөнгийн барьцааны гэрээ хийсэн. ТЭХуулийн 67,68 дугаар зүйлийн дагуу 109,376.4 мянган төгрөгийн өртэй 3 татвар төлөгчийн эд хөрөнгөд битүүмжлэх гэрээг хийж ажиллагаа явуулсан.

Татварын ерөнхий хуулийн татвар ногдуулалт, төлөлт хураалт болон хяналт шалгалтын процесс ажиллагаа хийгдсэн татварын өрийг гаргуулахаар Иргэний журмаар нэхэмжлэх, татварын албаны итгэмжлэлээр 21 аж ахуй нэгжийн 2,095,509.4 мянган төгрөгийн өрийг төлүүлэхээр шүүхэд нэхэмжилж 19 аж ахуй нэгжийн 1,490,903.9 мянган төгрөгийн өрөнд шүүхийн шийдвэр гаргуулан ажиллаж байна.

ШШГА-нд шүүхийн шийдвэр гарсан боловч өрөө төлж барагдуулахгүй байгаа 63 аж ахуй нэгжийн 4,443,566.3 мянган төгрөгийн өрийг шилжүүлэн шийдвэр гүйцэтгэгч нартай хамтран татварын өрийг барагдуулахаар ажиллаж 30 аж ахуй нэгжийн 473,542.7 мянган төгрөгийг барагдуулаад байна.

3.3. Татварт хамруулсан байдлын талаар

Татвар хамрагдалтын стандарт түвшинг хангаж ажиллахын тулд татварын өр, ногдлын дутуу үлдэгдэлтэй татвар төлөгч нэг бүрийг татварт хамруулахад анхааран ажиллаж байна.

Татварын төрөл	Хамруулбал зохих ТТТоо	Татвар төлсөн ТТТоо	Татварт хамруулалтын хувь
ААНОАТ	2048	1632	51.9%
НӨАТ	1616	1107	68.5%
ҮХЭХАТ	1586	824	51.9%
ХХОАТ	3066	2753	89.8%
НХАТ	672	448	66.7%
АТБӨЯХАТ	54631	40500	74.1%

3.4 Бусад ажлын талаар

АТБӨЯХАТ хураалтын ажил:

НЗД-ын 2017 оны 01 сарын 05-ны өдрийн А/09 дугаар захирамж, ЧДЗД-ын 2016 оны 01 сарын 18-ны өдрийн А/15 тоот захирамжийн дагуу АТБӨЯХАТатвар, АБТ, АЗАТөлбөр хураах ажлыг Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хүрээнд хийж гүйцэтгэж байна.

Хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллах зорилгоор албан татвар, төлбөр хураах ажлыг өдөр бүр хэлтэс, хэлтсийн татвар төлөгчдөд үйлчлэх тасаг, дүүргийн нэг цонхны үйлчилгээ, ЧД-ийн 12-р хорооны байр, “Эмон трейд” худалдааны төв зэрэг байршилүүдэд иргэн, ААН-д түргэн шуурхай үйлчилж байна.

АТБӨЯХАТатвар, АБТ, АЗАТөлбөрийн төлөвлөгөө гүйцэтгэлийн мэдээ:

Үзүүлэлт	2017.12.31-ний байдлаар /мян.төг/		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар	2,573,270.0	2,579,556.4	100.2%
Авто зам ашигласны төлбөр	1,168,747.3	1,144,989.1	97.9%
Агаарын бохирдлын төлбөр	122,900.8	109,953.8	89.5%

Нийт бүртгэлтэй 60255 тээврийн хэрэгсэл байгаагаас 6064 нь замын хөдөлгөөнд оролцдоггүй хэрнээ автотээврийн үндэсний төвөөс хасалтаа хийлгээгүй судалгааны хасуулахаар татварт хамрагдах 54631 тээврийн хэрэгслээс 40500 нь хамрагдаж 74.1 хувь хамрагдаад байна.

Дүүргийн замын цагдаагийн хэлтэстэй хамтран 2 ээлжийн хяналт шалгалтаар нийт 2346 ширхэг тээврийн хэрэгслийн гэрчилгээ хураагдаж ирсэнээс 2128 тээврийн хэрэгслийн гарчилгээг буцаан олгож АТБӨЯХАТатвараар 108,219.8 мянган төгрөг, Автозам ашигласны төлбөрт 54,052.9 мянган төгрөг, Агаарын бохирдлын төлбөрт 3,974.9 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлж ажиллалаа.

Мөн нээлттэй хаалганы өдөрлөгийг 10,11 дүгээр саруудад дүүргийн хороодод зохион явуулж татвараа төлөх болон авто тээврийн үндэсний төвийн хасагдах жагсаалтанд орсон эсэхийг шалган хасагдах өргөдлийг хүлээн авч ажилласан.

Энэ хугацаанд 1317 татвар төлөгч иргэн, аж ахуй нэгжийн хасагдах хүсэлтийг хүлээн авч автотээврийн үндэсний төвд хүргүүлэн ажилласан.

Хог хаягдлын хураамж:

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн талаар дүүргийн нутаг дэвсгэрт байрлах ААНБ болон иргэдтэй өнгөрсөн онд хийсэн гэрээг үйл ажиллагааны чиглэл, талбайн хэмжээ зэрэг үзүүлэлтүүдийг үндэслэн гэрээний дүнг нэмэгдүүлэн шинэчилж ирэх онд төлөх хог хаягдлын төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэв. Мөн өссөн дүнгээр 514 ААН, иргэнтэй 2017 оны гэрээг шинэчлэн байгуулсан. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөвлөгөө 1,306,320.0 мян/төг, гүйцэтгэл 1,383,159.2 биелэлт 105.9 хувь байна. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг УБ банкны 2611180381 тоот дансанд 3990 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас хураан төвлөрүүлсэн. Гэрээ хийсэн ААНБ-дад сар бүр төлбөрийн нэхэмжлэлийг холбогдох нягтлан бодогч, менежер нарт хүргүүлэн ажиллаж байна.

Гэрээ хийсэн ААН, иргэний үйл ажиллагааны чиглэл, талбайн хэмжээ, ЧД-ийн ИТХ-ын 23 тоот тогтоолын тариф зэргийг үндэслэн Төрийн банкны Ард бизнес төв, Занабазар салбаруудыг 35000-150000 төгрөг, ХААН банкны Тэнгис тооцооны төв 50000-150000 төгрөг, Говь Хангай мебель 30000-112000 төгрөг, Улаанбаатар Эрдэм дээд сургууль 100000-130000 төгрөг, Макс Өргөө ХХК 120000-290000 төгрөг болгон тус тус хог хаягдлын төлбөрийн тарифыг шинэчлэн тогтоож уг тарифын дагуу хог хаягдлын гэрээ хийж төлбөрийг хураан төвлөрүүлж байна.

Мөн хог хаягдлын гэрээ хийгдсэн аж ахуйн нэгж иргэдийн бүртгэл хөтлөх, программд шинээр хийгдсэн гэрээг цаг тухайд нь шивж бүртгэх, шаардлагатай мэдээ судалгааг гарган ажилласнаар программд бүртгэлтэй хугацаа дууссан гэрээний жагсаалтыг гарган аж ахуйн нэгж иргэдтэй холбогдож гэрээ сунгуулах талаар сануулж гэрээгээ шинэчлэхийг шаардаж байна.

Хөнгөлөлт чөлөөлөлтийн тайлан:

ХХОАТХ-ийн ИОТТХ-аар тайлан гаргах талаар 19 хороо, томоохон худалдааны төвд үйл ажиллагаа явуулж буй иргэдэд сургалт сурталчилгаа явуулж, тайлангийн маягыг ажлын байранд нь хүргэж заавар зөвлөгөө өгч аж ахуй эрхлэгч иргэдээс “ХХОАТ тодорхойлох тайлангийн хуудас”-аар 3956 тайлан хүлээн авч тайланг шивж программд орууллаа.

Татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн 2637 тайлан хүлээн авснаас давхардсан буюу хасагдах тайлан 75 байсныг хассанаар нийт 2016 оны татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн 2562 тайланг татварын хяналт шалгалтаар шалгуулан нэгтгэл судалгааг НТГ-т хүргүүлсэн. Үүнд: Дотоодын сургалтын төлбөрийн хөнгөлөлтийн тайлан 1353, гадаад сургалтын төлбөрийн хөнгөлөлтийн тайлан 32, орон сууцны анхны удаагийн чөлөөлөлтийн тайлан 507, орон сууцны чөлөөлөлтийн үргэлжлүүлэн авч байгаа тайлан 813-ыг тус тус хүлээн авсан байна. Хүлээн авсан эдгээр тайланг хороо тус бүрээр хөнгөлөлт, чөлөөлөлтийн төрлөөр ангилан архивын журмын дагуу үдэж хавтаслан, товъёоглож архивт хүлээлгэн өгөхөд бэлэн болгож байна.

Хөнгөлөлтийн төрөл	Татвар төлөгчийн тоо	Дүн	Нэгтгэл
Орон сууц анхны жил	498	641,415,824.59	1,246,928,031.07
Орон сууц давтан	801	605,512,206.48	
Дотоод сургалт	1227	277,448,615.64	314,648,356.50
Гадаад сургалт	35	37,199,740.86	
Нийт	2561	1,561,576,387.57	1,561,576,387.57

ДӨРӨВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД:**4.1.Төлөвлөгөөт хяналт шалгалтын талаар:**

ТЕГ-ын Эрсдлийн удирдлагын хэлтсээс эрсдэлд суурилсан татварын хяналт шалгалтын 2017 оны төлөвлөгөөгөөр шалгагдах 316 татвар төлөгчдийн нэрс ирснээс 316 томилолтыг олгож, гүйцэтгэл 100 хувьтай байна.

4.2.Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын талаар:

Тайлант хугацаанд 128 төлөвлөгөөт бус томилолт олгогдсоноос 117 татвар төлөгчдийн шалгалтыг дуусгаж гүйцэтгэл 91,4 хувьтай байна.

Хяналт шалгалтын нийт шийдвэрийг төрлөөр нь авч үзвэл НӨАТ-ын илүү төлөлтийг баталгаажуулсан акт 6, илтгэх хуудас 53, акт 184, дүгнэлт 8 үйлджээ. Хяналт шалгалтаар нийт 352,326.7 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 29,332.5 төгрөгийн нөхөн татвар, 30,756.3 төгрөгийн хүү, 882,969.4 сая төгрөгийн торгууль, 540,355.7 сая төгрөгийн алданги, нийт 30,756.3 тэрбум төгрөгийн төлбөр ногдуулсан байна.

2017 онд дээд газрын 2 тусгай удирдамжийн дагуу хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. ТЕГ-ын даргын баталсан 2017 оны 01 сарын 18-ны 2017/01 дугаартай “Хяналт шалгалт хийх ажлын удирдамж”-ийн хүрээнд нэр бүхий 13 иргэдийг хөндлөнгийн мэдээллийн дагуу шалгаснаас өөр дүүрэгт бүртгэлтэй 2 иргэнийг харьяаллын дагуу шилжүүлж, 11 иргэдийг шалгаж илтгэх хуудас 2, 9 акт үйлдэж 142,6 сая төгрөгийн зөрчил илрүүлэн, 11,2 сая төгрөгийн нөхөн татвар, 3,3 сая төгрөгийн торгууль, 3,9 сая төгрөгийн алданги, нийт 18,5 сая төгрөгийн төлбөр ногдуулсан.
2. ОАТТХ, Онцгой албан татварын тэмдгийн тухай хууль зэрэг хуулиудын хэрэгжилтийг шалган илэрсэн зөрчлийг арилгуулах, зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн хүрээнд шийдвэрлэхээр ирүүлсэн удирдамжийн хүрээнд ЧД-ийн нутаг дэвсгэр дээр байрлах татвар төлөгчдийн Онцгой албан татварын тэмдгийн хуулийн хэрэгжилтийг шалгасан. Үүнд тус дүүргийн 1-19 дүгээр хороодоор 2017 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс 2017 оны 02 дугаар сарын 24-ний өдрийг дуустлах хугацаанд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Нийт 12 татварын улсын байцаагчийг 6 хэсэг болгон нэг хэсэгт 3-4 хороо хариуцуулан ажилласан.

Нийт 514 татвар төлөгч шалгахаас 473 татвар төлөгчийг шалгасан бөгөөд үйл ажиллагааны чиглэлээр ангилан авч үзвэл бөөний цэг 9, хүнсний нэрийн барааны дэлгүүр 287, караоке паб 45, ресторан бар 128, зочид буудал 4 татвар төлөгчийн Онцгой албан татварын тэмдгийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж акцны зөрчилтэй архи, согтууруулах ундааг хурааж авсан.

4.3.Хөндлөнгийн мэдээллийн ажлын талаар:

2017 оны 12 сарын 31-ний Тайлант хугацаанд нийт 13,9 тэрбум төгрөгийн дүнтэй 690 ширхэг хөндлөнгийн мэдээллийг цуглуулж хөндлөнгийн мэдээллийн баазад бүртгэн Эрсдэл, статистикийн тасагт хүргүүлж ажиллалаа. Хөндлөнгийн мэдээллийн баазаас 58 татвар төлөгчидтэй холбоотой 5,1 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 377,2 сая төгрөгийн нөхөн татвар, 54,5 сая

төгрөгийн төлбөр, 86,2 сая төгрөгийн алданги, 6,565.00 төгрөгийн хүү, нийт 517,9 сая төгрөгийн төлбөрийг ногдууллаа. Хяналт шалгалт хийх явцдаа хөндлөнгийн мэдээллийн санг байнга ашиглахаас гадна, холбогдох албан байгууллагуудад албан тоот илгээж мэдээлэл авч ажиллалаа.

4.4.Маргаантай актны шийдвэрлэлтийн талаар:

Тайлант оны эхэнд нийт 40 татвар төлөгчтэй холбоотой 3,360,986.600.00 төгрөгийн маргаантай акт байснаас 16 татвар төлөгчийн 746,571,700.00 төгрөгийн маргаантай акт эцэслэн шийдвэрлэгдсэн байна. 4 татвар төлөгчийн 211,442,500.00 төгрөгийн акт шүүхийн шатанд хянагдаж, 24 татвар төлөгчийн 2,402,972.400.00 төгрөгийн акт маргаан таслах зөвлөлд байна. Тайлант онд 9 татвар төлөгчтэй холбоотой 8,440,123,740.00 төгрөгийн маргаантай акт үүссэн байна.

Татварын хяналт шалгалт




Хяналт шалгалтын ажлын талаар;



- 2016 онд хүү, алданги, торгууль нийт 1.5 тэрбум төгрөг
- 2017 онд хүү, алданги, торгууль нийт 1.4 тэрбум төгрөг

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГҮЙЦЭТГЭЛ



Маргаантай акт, дүгнэлтийн шийдвэрлэлтийн судалгааг НТГ-ын хяналт, шалгалтын хэлтэс, ТЕГ-ын татварын хяналт шалгалт арга зүйн газарт явууллаа. Мөн дүгнэлтийн шийдвэрлэлтийн байдлыг цагдаагийн газар болон прокурорын газарт албан бичиг явуулан тодрууллаа.

ТАВ. ЭРСДЭЛ СТАТИСТИКИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД:

5.1. Эрсдэлийн мэдээлэл, судалгаа, шинжилгээний ажлын талаар:

ТЕГ-ын даргын 2012 оны 31 дүгээр тушаалаар батлагдсан “ҮТА-ны татварын эрсдэлийн нүнэлгээний дүрэм”-ийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасны дагуу 2017 онд татварын хяналт шалгалтад хамруулах 19 татвар төлөгчдийн сонголт хийж саналыг ТЕГ хүргүүлсэн. 2017 онд хяналт шалгалтад хамрагдах татвар төлөгчдийг сонгохдоо холбогдох нэгжүүдээс санал авсан бөгөөд татвар төлөгчдийн бүртгэлээс тусгаарлагдсан, эрэн сурвалжлагдаж байгаа зэрэг шалтгаантай татвар төлөгчдийг хамруулахгүй байх чиглэл баримталсан болно.

5.2. Статистикийн чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын талаар:

Хэлтсийн даргын 2016 оны 12-р сарын 21-ний өдрийн А/72 дугаар тушаалаар хяналт шинжилгээ үнэлгээний тайлан мэдээг батлагдсан маягтын дагуу гаргах байнгын ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хүрээнд 2017 оны үйл ажиллагаа, гүйцэтгэлийн хүрэх түвшиний шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажилласан үр дүнг сар бүр холбогдох нэгжүүдээс авч нэгтгэж, 2017 оны хагас жилийн хяналт шинжилгээ үнэлгээгээр 82.85В дүнтэй дүгнүүлсэн.

Мөн түүнчлэн шалгуур хангаагүй үзүүлэлтүүдийг нэгтгэн уг үзүүлэлтүүдийн үр дүнг нэмэгдүүлэн ажиллах зөвлөмжийг холбогдох нэгжүүдэд хүргүүлэн ажилласан. Зөвлөмжийн үр дүнд 12 сарын байдлаар хэлтсийн нийт дундаж үзүүлэлт 85.32В гэсэн үнэлгээтэй байна.

5.3. Техник, технологийн ажлын талаар:

ЧД-ийн татварын хэлтсийн мэдээлэл боловсруулах иж бүрэн систем болон сүлжээ түүнд тулгуурласан татварын төвлөрсөн мэдээллийн баазын үйл ажиллагааны техникийн боломжийг хангах, татварын албаны хэмжээнд мэдээллийн санг үүсгэх, баяжуулах, төвлөрсөн мэдээллийн

санд төвлөрүүлэх, удирдлага болон дотоод хэрэглэгчдийг мэдээллээр хангах зорилтыг хэрэгжүүлэн ажилласан.

Хэлтсийн интернетийн сүлжээг Skynetwork компанийн шилэн кабель ашиглан, Мобинэтийн сүлжээг хянаж доголдуулалгүй ажиллуулан, Юнивишн компанийн интернетийн сүлжээг ашиглан сүлжээ хэвийн явагдан ажиллаж байна.

ТЕГ-аас 3 ширхэг, ЧД-ийн төрийн сангийн хөрөнгө оруулалтаар 17 ширхэг иж бүрэн компьютер хүлээн авч хэлтсийн хэмжээнд нийт 134 ш компьютер, 11 ш зөөврийн нөүтбүүк, 45 ш принтер, 10 ш сүлжээ салаалагч (Switch), 1 түгээгч (ROUTER), 1 Хөрвүүлэгч(Media Converter) –ийн хэвийн үйл ажиллагаагаа ханган ажиллаж байна.

Хяналтын камер 1 цэгийн үйлчилгээний танхимд 1 ширхэг, 2 давхарын коридорт 1 ширхэг, 3 давхарын коридорт 3 ширхэг нийт 5 ширхэг камер хэвийн горимоор ажиллаж байна.

“Жайка” Олон улсын байгууллагын тусламжаар 40 компьютер хүлээн авч хэрэгцээт програмуудыг инсталдаж суулгасан. Мөн хэлтэсийн бүх компьютерт вирусны програм суулгасан.

ЗУРГАА. НӨАТХ-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД:

НӨАТ-ын тухай хууль, НХАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, ТЕГ-ын даргын 2017 оны А/59 дүгээр тушаал, ЧД-н Засаг даргын 2017 оны А/149 дүгээр захирамжийг тус тус үндэслэн Хэлтсийн даргаар тушаал батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус тушаал, захирамжийн дагуу төсвийн орлогын тогтвортой орчныг бүрдүүлж, татварын баазыг өргөжүүлэх, нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системд хэрэглэгчээр бүртгэх, бүртгэлийн машин хэрэглэж байгаа эсэхэд хяналт тавих, нийслэл хотын албан татварын тухай хууль, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, баазыг цэгцлэх, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх ажлын хүрээнд Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн 1,2 дугаар хэлтэс, Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс, Бүртгэлийн хэлтэстэй хамтарсан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Татвар төлөгчийг НӨАТ-ын нэгдсэн системд холбосон байдал:

Үзүүлэлт		Нэгдсэн системд		Холболтын хувь
		Холбогдвол зохих	холбогдсон	
НӨАТ суутган төлөгч	Бүгд	3268	2967	90.8%
	Аж ахуй нэгж	3205	2917	91.0%
	Хувь хүн	63	50	79.4%
НӨАТ суутган төлөгч биш	Бүгд	7165	3461	48.3%
	Аж ахуй нэгж	4283	2214	51.7%
	Хувь хүн	2882	1247	43.3%

Цахим төлбөрийн баримтын нэгдсэн системд холбогдвол зохих нийт 10433 татвар төлөгчийн 6428 татвар төлөгч иргэн, аж ахуй нэгж буюу 61.6 хувь нь холбогдсон байна.

2017 оны 12 сарын 31-ны байдлаар нийт холбогдсон 6428 татвар төлөгч иргэн, аж ахуй нэгжээс 1434 нь 2017 онд шинээр бүртгүүлэн холбогдсон байна.

Цахим төлбөрийн баримтын системд холбогдоогүй болон татварын албаны шаардлага биелүүлээгүй зөрчилтэй 12 татвар төлөгчийг шийтгэлийн хуудас бичиж 1,560.0 мянган төгрөгөөр торгосон болно.

Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах зах худалдааны төвүүдэд нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зах худалдааны төвүүдэд түрээсийн гэрээгээр үйл ажиллагаа эрхэлж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг иргэдэд үйчлэхдээ е-баримт олгох, стандартын шаардлага хангасан кассын машин, хэвлэх төхөөрөмж, хэвлэлийн хор, тасалбарын цаас, пос терминал төхөөрөмж хэрэглэх талаар хуульчилж өгсөний дагуу хамтран ажиллах санал хүсэлт авах тухай албан бичгийг хүргүүлсэн.

Чингэлтэй дүүргийн худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтран 1-19-р хороодын тусгай зөвшөөрөл эзэмшдэг аж ахуй нэгжүүдэд НХАТ, НӨАТ-ын хуулийн хэрэгжилт, кассын машин, е-баримт талаарх сургалтыг явуулсан.

ДОЛОО. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГАТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

- 2017 оны 01 сарын 19-ний өдөр Монголын Улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4, 8.5 дахь заалт болон “Донорын тухай” хуулийг хэрэгжүүлэх хүмүүнлэгийн үйлсэд хувь нэмрээ оруулж, ЧД-ийн Улаан загалмайн хороотой хамтран ажилласан.



- СХДүүргийн харьяат төрөлхийн 4 мөчний ясжилтын дутуу хөгжил, гаж хөгжил хавсарсан гэсэн оноштой Ш. Буянжаргалын эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Нэг баг-1000 төгрөг” сайн үйлсийн аянд нэгдэж хэлтсийн хамт олноос 99000 төгрөгийн хандив үзүүлсэн.
- Татварын албанд мөр зэрэгцэн ажиллаж байгаа СБД-ийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч С. Болорчимэгийн эмчилгээний зардалд хэлтсийн албан хаагчдаас 1065000 төгрөгийг хандивласан.
- Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот үүсч байгуулагдсаны 378 жилийн ойд зориулсан “Улаанбаатар-Марафон-2017” олон улсын IV удаагийн гүйлт 2017 оны 05 сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан. Энэ арга хэмжээнд Татварын орлогийн тасгийн Татварын улсын байцаагч Ц. Алтанхуяг, С. Цэендолгор, Хувь хүний татварын тасгийн Хураагч Т. Оргил нар амжилттай оролцсон.



- Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор 2017 оны хаврын бүх нийтээр мод тарих өдрийг 05 сарын

13-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлсэн. Бүх нийтээр мод тарих өдрийн нээлт хийж ЧД-ийн Татварын хэлтсийн хамт олон 57 дугаар дунд сургуульд 2014 онд бүтээн байгуулсан ЧД-ийн Татварын хэлтсийн нэрэмжит ногоон төгөлийн ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэж, хашаа пайз зэргийг будаж, хөрсийг сэргээн, цэцгэн мандал хийн, шинээр чацаргана, агч, голт бор, монос зэрэг нэр төрлийн 5 ширхэг мод бут, сөөгийг шинээр тарьж, усалгаа арчилгаа хийсэн.



- ЗГ-ын 2017 оны 67 дугаар тогтоолын дагуу 2017 оны 03 сарын 22-ны өдөр “ Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийг Монгол улсын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлсэн. ЧД-ийн татварын хэлтсийн хамт олон гамшгийн дуут дохиогоор өрөө тасалгаанд аюул багатай байрлалд өөрийгөө хамгаалах арга хэмжээг авч ширээн доогуур орж, даацын хана, булан тохойд зогсож байрлан, хэлтсийн байрыг орхин аюулгүй зай талбайд гарч зааврын дагуу оролцсон.



- Бүх нийтийн их цэвэрлэгээг 2017 оны 02 сарын 18-ны өдөр болон 04 дүгээр сарын 1, 2-ны өдрүүдэд Засаг даргын Тамгын газраас дүүргийн хэмжээнд зохион байгуулж ажилласан. Энэхүү арга хэмжээнд хэлтсийн албан хаагчид идэвхитэй оролцсон.



- Чингэлтэй Дүүргийн 25жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохиогдсон “Төрийн албан хаагчдын урлагийн наадам-2017”-д ЧД-ийн Татварын хэлтсийн хамт олон амжилттай оролцлоо.



- Шинэ хос номин оюу ТББ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2017 оны 06 сарын 01-ний өдөр 25 хүүхдэд бэлэг дурсгалын зүйл гардуулсан.
- Чингэлтэй дүүргийн 25 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Чингэлтэй дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн “Ногоон дүүрэг” зорилтын хүрээнд болон “Ойн тухай хууль”-ийн 31 дүгээр зүйл, “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр зарлах тухай” Монгол улсын Ерөнхийлөгчийн 63 дугаар зарлигийг хэрэгжүүлж дүүргийн нутаг дэвсгэрт ногоон байгууламж нэмэгдүүлэх, иргэдэд түүнийг арчлан хамгаалах дадал, ухамсар төлөвшүүлэх, бүх нийтийн үйл хэрэг болгох зорилготой “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” 2017 оны 10 срын 14-ний өдөр зохион байгуулагдсан.



- 2017 оны 11 сарын 3-ны өдөр Чингэлтэй дүүргийн 14-р хороонд амьдардаг 7 хүүхэдтэй, өрх толгойлсон эцэг Ж.Энхбат гэх иргэнд хүнсний болон ахуйн хэрэглээний багахан хэмжээний сэтгэлийн дэм, тусламж үзүүлсэн.



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.БАТБАЯР